



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/96/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Л.Дамдинжав

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БСШУЯ | Боловсрол соёл шинжлэх ухааны яам |
| ОНХС | Орон нутгийн хөрөнгө оруулалтын сан |
| БШУ | Боловсрол шинжлэх ухаан |

Агуулга

| | |
|--|----|
| 1.Аудитын санал, дүгнэлт | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 8 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 10 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 11 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 13 |
| 3.Аудитын тайлан | 14 |
| 3.1. Ерөнхий зүйл | 14 |
| 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 14 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 15 |
| 3.4. Материаллаг байдал..... | 15 |
| 3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга | 15 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 16 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 17 |
| 3.8 Аудитын гол асуудал..... | 18 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 18 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 18 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 18 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 18 |
| 4. Аудитын илрүүлэлт..... | 19 |
| 4.1 Залруулсан алдаа | 19 |
| 4.2 Төлбөрийн акт..... | 19 |
| 4.3 Зөвлөмж | 19 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 20 |



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/96-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

АЛТАНБУЛАГ СУМЫН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ж.МӨНХТУЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 29,066,605.66 | 34,851,979.90 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 0.00 | 0.00 |
| 31100 | Кассанд байгаа бэлэн мөнгө | 0.00 | 0.00 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 0.00 | 0.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 29,066,605.66 | 34,851,979.90 |
| 35100 | Түүхий эд материал | 0.00 | 0.00 |
| 35400 | Хангамжийн материал | 29,066,605.66 | 34,851,979.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 847,500.00 | 122,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 28,219,105.66 | 32,228,287.90 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.00 | 1,400,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 0.00 | 1,101,692.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 299,379,541.71 | 297,823,654.81 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 299,379,541.71 | 297,823,654.81 |
| 39200 | Биет хөрөнгө | 257,293,916.74 | 256,050,529.88 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 220,198,105.00 | 220,198,105.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (11,121,323.76) | (16,969,760.76) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 46,458,208.40 | 34,731,927.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (29,962,242.80) | (11,658,791.30) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,137,465.62 | 20,506,628.82 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (18,545,998.11) | (12,464,339.23) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 28,070,370.00 | 33,070,370.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (9,440,667.61) | (11,363,610.35) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 0.00 | 0.00 |
| 39217 | Ном | 1,500,000.00 | 0.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 42,085,624.97 | 41,773,124.93 |
| 39301 | Програм хангамж | 1,700,000.00 | 1,700,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (684,375.03) | (996,875.07) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 41,070,000.00 | 41,070,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 328,446,147.37 | 332,675,634.71 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 0.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 328,446,147.37 | 310,838,746.51 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 328,446,147.37 | 310,838,746.51 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 231,190,094.00 | 231,190,094.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 65,131,108.41 | 47,523,707.55 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 65,131,108.41 | 65,131,108.41 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (17,607,400.86) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 32,124,944.96 | 32,124,944.51 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 328,446,147.37 | 310,838,746.51 |

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 418,001,258.00 | 429,695,128.00 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 0.00 | 0.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,414,940.00 | 16,359,590.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,414,940.00 | 16,359,590.10 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 5,248,500.00 | 15,918,444.10 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 166,440.00 | 441,146.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 412,586,318.00 | 413,335,538.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 399,630,700.00 | 396,711,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 399,630,700.00 | 396,711,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 1,498,495.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 1,498,495.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 12,955,618.00 | 15,126,043.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 12,955,618.00 | 15,126,043.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 437,605,083.29 | 423,128,606.91 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 437,605,083.29 | 423,128,606.91 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 378,504,273.29 | 376,003,716.27 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 282,447,209.00 | 284,713,399.00 |
| 210101 | Үндсэн цалин | 164,167,300.00 | 220,477,626.00 |
| 210102 | Нэмэгдэл | 73,318,650.00 | 43,232,173.00 |
| 210104 | Урамшуулал | 21,271,790.00 | 21,003,600.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 23,689,469.00 | 0.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,468,781.00 | 36,794,645.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,132,323.00 | 25,528,899.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,834,116.00 | 2,843,268.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,267,291.00 | 2,294,616.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 566,821.00 | 584,349.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,668,230.00 | 5,543,513.36 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,148,898.00 | 11,703,143.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,648,898.00 | 7,203,143.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,500,000.00 | 3,960,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 540,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,178,465.28 | 10,677,863.76 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,329,600.00 | 279,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 473,400.00 | 633,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 401,600.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,441,790.00 | 705,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,532,075.28 | 511,091.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 8,548,272.76 |

| | | | |
|-------------|--|------------------------|-----------------------|
| 2105 | Нормативт зардал | 13,160,777.00 | 11,481,868.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 55,000.00 | 61,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 13,105,777.00 | 10,771,468.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 648,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,664,910.00 | 873,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,664,910.00 | 873,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 14,000.00 | 53,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,000.00 | 53,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 654,000.00 | 861,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 330,000.00 | 375,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 486,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,767,233.01 | 18,844,497.15 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,243,100.00 | 1,757,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15,524,133.01 | 17,087,297.15 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 59,100,810.00 | 47,124,890.64 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 59,100,810.00 | 47,124,890.64 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 59,100,810.00 | 47,124,890.64 |
| 213504 | Хөрөнгийн | 0.00 | 0.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | (19,603,825.29) | 6,566,521.19 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0.00 | 2,337,033.85 |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 0.00 | 2,337,033.85 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | | (2,337,033.85) |
| VI | НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | (19,603,825.29) | 4,229,487.34 |
| VI-I | Засгийн газрын хувь оролцоо | 0.00 | 0.00 |
| VI-II | Хяналтын бус хувь оролцоо | 0.00 | 0.00 |

2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-----------|--|-----------------------|-----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 413,936,621.00 | 413,335,538.00 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 0.00 | 0.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,350,303.00 | 0.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,350,303.00 | 0.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,350,303.00 | 0.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,350,303.00 | 0.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 412,586,318.00 | 413,335,538.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 399,630,700.00 | 396,711,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 399,630,700.00 | 396,711,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 1,498,495.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 1,498,495.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 12,955,618.00 | 15,126,043.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 12,955,618.00 | 15,126,043.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 407,286,621.00 | 411,385,538.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 407,286,621.00 | 411,385,538.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 346,835,508.00 | 364,260,647.36 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 282,447,209.00 | 284,713,399.00 |
| 210101 | Үндсэн цалин | 164,167,300.00 | 220,477,626.00 |
| 210102 | Нэмэгдэл | 73,318,650.00 | 43,232,173.00 |
| 210104 | Урамшуулал | 21,271,790.00 | 21,003,600.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 23,689,469.00 | 0.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,468,781.00 | 36,794,645.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,132,323.00 | 25,528,899.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,834,116.00 | 2,843,268.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,267,291.00 | 2,294,616.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 566,821.00 | 584,349.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,668,230.00 | 5,543,513.36 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,148,898.00 | 13,103,143.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,648,898.00 | 7,203,143.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,500,000.00 | 5,360,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 540,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,340,500.00 | 1,907,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 866,700.00 | 279,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 473,400.00 | 633,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 401,600.00 | 0.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 40,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,540,000.00 | 520,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,018,800.00 | 474,100.00 |
| 2105 | Нормативт зардал | 6,105,300.00 | 20,583,560.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 55,000.00 | 61,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,466,300.00 | 11,873,160.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 584,000.00 | 8,648,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,729,420.00 | 4,446,600.00 |

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 1,550,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,729,420.00 | 2,896,600.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 14,000.00 | 53,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,000.00 | 53,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 903,000.00 | 901,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 579,000.00 | 415,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 486,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,678,400.00 | 1,757,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,678,400.00 | 1,757,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 60,451,113.00 | 47,124,890.64 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.00 | 0.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,350,303.00 | 0.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,350,303.00 | 0.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 59,100,810.00 | 47,124,890.64 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 59,100,810.00 | 47,124,890.64 |
| 213504 | Хөрөнгийн | 0.00 | 0.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 6,650,000.00 | 1,950,000.00 |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | 0.00 | 0.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 6,650,000.00 | 1,950,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 6,650,000.00 | 1,950,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 6,650,000.00 | 1,950,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,650,000.00 | 1,950,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (6,650,000.00) | (1,950,000.00) |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---|---------------------------------|-----------------------|----------------------|---|
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 231,190,094.00 | 32,124,944.96 | 65,131,108.41 | 328,446,147.37 |
| 11 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 231,190,094.00 | 32,124,944.96 | 65,131,108.41 | 328,446,147.37 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 231,190,094.00 | 32,124,944.96 | 65,131,108.41 | 328,446,147.37 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (17,607,400.86) | (17,607,400.86) |
| 20 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 231,190,094.00 | 32,124,944.96 | 47,523,707.55 | 310,838,746.51 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | харьцуулалт |
|-------------|---|-----------------------|-----------------------------|----------------------|----------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 419,119,300.00 | 364,712,152.36 | 54,407,147.64 | 87.02% |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 419,119,300.00 | 364,712,152.36 | 54,407,147.64 | 87.02% |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 419,119,300.00 | 364,712,152.36 | 54,407,147.64 | 87.02% |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 315,577,500.00 | 283,462,292.00 | 32,115,208.00 | 89.82% |
| 210101 | Үндсэн цалин | 245,833,000.00 | 220,477,626.00 | 25,355,374.00 | 89.69% |
| 210102 | Нэмэгдэл | 48,740,900.00 | 41,981,066.00 | 6,759,834.00 | 86.13% |
| 210104 | Урамшуулал | 21,003,600.00 | 21,003,600.00 | | 100.00% |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 41,113,600.00 | 36,638,257.36 | 4,475,342.64 | 89.11% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,490,500.00 | 25,422,555.00 | 3,067,945.00 | 89.23% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,155,800.00 | 2,830,757.00 | 325,043.00 | 89.70% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,524,600.00 | 2,284,607.00 | 239,993.00 | 90.49% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 631,200.00 | 581,847.00 | 49,353.00 | 92.18% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,311,500.00 | 5,518,491.36 | 793,008.64 | 87.44% |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,385,400.00 | 13,103,143.00 | 7,282,257.00 | 64.28% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,505,400.00 | 7,203,143.00 | 4,302,257.00 | 62.61% |
| 210302 | Түлш, халаалт | 8,100,000.00 | 5,360,000.00 | 2,740,000.00 | 66.17% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 780,000.00 | 540,000.00 | 240,000.00 | 69.23% |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,816,500.00 | 1,816,500.00 | 0.00 | 100.00% |
| 210401 | Бичиг хэрэг | 296,700.00 | 279,500.00 | 17,200.00 | 94.20% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 276,400.00 | 633,900.00 | (357,500.00) | 229.34% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 0.00 | 300,000.00 | 0.00% |
| 210404 | Ном, хэвлэл | 40,300.00 | 0.00 | 40,300.00 | 0.00% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 429,000.00 | 429,000.00 | | 100.00% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 474,100.00 | 474,100.00 | | 100.00% |
| 2105 | Нормативт зардал | 30,586,100.00 | 20,583,560.00 | 10,002,540.00 | 67.30% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 61,700.00 | 61,500.00 | 200.00 | 99.68% |
| 210502 | Хоол, хүнс | 21,875,500.00 | 11,873,160.00 | 10,002,340.00 | 54.28% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,648,900.00 | 8,648,900.00 | | 100.00% |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,396,600.00 | 6,396,600.00 | | 100.00% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,500,000.00 | 3,500,000.00 | | 100.00% |
| 210604 | Урсгал засвар | 2,896,600.00 | 2,896,600.00 | | 100.00% |
| 2107 | Томилолт, зочны зардал | 98,800.00 | 53,000.00 | 45,800.00 | 53.64% |

| | | | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|----------------------|----------------|
| 210702 | Дотоод албан томилолт | 98,800.00 | 53,000.00 | 45,800.00 | 53.64% |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,387,600.00 | 901,600.00 | 486,000.00 | 64.98% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 415,600.00 | 415,600.00 | | 100.00% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 972,000.00 | 486,000.00 | 486,000.00 | 50.00% |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,757,200.00 | 1,757,200.00 | | 100.00% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,757,200.00 | 1,757,200.00 | | 100.00% |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 419,119,300.00 | 364,712,152.36 | 54,407,147.64 | 87.02% |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 396,711,000.00 | 349,586,109.36 | 47,124,890.64 | 88.12% |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 396,711,000.00 | 349,586,109.36 | 47,124,890.64 | 88.12% |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 22,408,300.00 | 15,126,043.00 | 7,282,257.00 | 67.50% |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 22,408,300.00 | 15,126,043.00 | 7,282,257.00 | 67.50% |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | | 100.00% |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | | 100.00% |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 28.00 | 28.00 | | 100.00% |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | | 100.00% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9.00 | 9.00 | | 100.00% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 18.00 | 18.00 | | 100.00% |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 136.00 | 136.00 | | 100.00% |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 136.00 | 136.00 | | 100.00% |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 136.00 | 136.00 | | 100.00% |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 26.00 | 26.00 | | 100.00% |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|-------------|---|------------|--------------|----------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 1,498,495.00 | (1,498,495.00) |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,498,495.00 | (1,498,495.00) |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,498,495.00 | (1,498,495.00) |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,251,107.00 | (1,251,107.00) |
| 210101 | Үндсэн цалин | | | - |
| 210102 | Нэмэгдэл | | 1,251,107.00 | (1,251,107.00) |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | - |
| 210104 | Урамшуулал | | | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 156,388.00 | (156,388.00) |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 106,344.00 | (106,344.00) |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 12,511.00 | (12,511.00) |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 10,009.00 | (10,009.00) |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 2,502.00 | (2,502.00) |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 25,022.00 | (25,022.00) |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | | - |
| 210302 | Түлш, халаалт | | | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | | | - |
| 210304 | Байрны түрээс | | | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 91,000.00 | (91,000.00) |
| 210401 | Бичиг хэрэг | | | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | | | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | | - |
| 210404 | Ном, хэвлэл | | | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 91,000.00 | (91,000.00) |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | | - |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 1,498,495.00 | (1,498,495.00) |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 1,498,495.00 | (1,498,495.00) |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | | - |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,498,495.00 | (1,498,495.00) |

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн /Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримт, хүнсний материалын худалдан авалттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Л.Дамдинжав, аудиторын туслах Ж.Сайнбилэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэг нь “Хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг чанартай, хүртээмжтэй олгож, хүмүүнлэг, оюунлаг, чадварлаг иргэн болох харгуйг нээж өгөхөд оршино” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 437,605.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,376.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,063.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,229.5 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------|----------------|-----------------|-----------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Бараа материал | 29,066.6 | 34,852.0 | (5,785.4) |
| Үндсэн хөрөнгө | 299,379.5 | 297,823.6 | 1,555.9 |

| | | | |
|---|------------------|------------------|----------------|
| Нийт хөрөнгө | 328,446.1 | 332,675.6 | 4,229.5 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 328,446.1 | 332,675.6 | 4,229.5 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 328,446.1 | 332,675.6 | 4,229.5 |

Бараа материал дансны үлдэгдэл 5,785.4 мянган төгрөгөөр буурсан нь БШУЯ-аас 441.1 мянган төгрөгийн ариутгалын материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан төсвийн хөрөнгөөр 34,003.9 мянган төгрөгийн бараа материал бэлтгэсэн, цэцэрлэгийн “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 2021 оны 11 дүгээр сарын 12-ний өдрийн дүгнэлтийг үндэслэн 8,548.3 мянган төгрөгийн аж ахуйн материал акталж данснаас хассан, 20,111.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд /анхны өртгөөр/ 17,857.1 мянган төгрөгөөр буурсан нь сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 5,000.0 мянган төгрөгийн гадна тоглоом хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 1,950.0 мянган төгрөгийн хөргөгч худалдан авсан, сумын ИТХТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн 65 дугаар тогтоолоор 2,337.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 13,888.7 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан, Орон нутгийн өмчийн даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 649 дүгээр албан бичгийг үндэслэн хөрөнгийн үнэлгээг 10,918.5 мянган төгрөгөөр бууруулснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 332,675.6 мянган төгрөг болж 4,229.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 11,693.8 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар өсөхөд үнэ төлбөргүй хөрөнгө нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 14,476.4 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан нь хоол хүнсний зардал буурснаас голлон шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 437,638.2 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа нь танхим болон танхимын бус үйл ажиллагаанд шилжүүлсэнтэй холбоотойгоор төсөвт өөрчлөлт орсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр **419,119.3** мянган төгрөгийн төсөв баталснаас 396,711.0 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 22,408.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 396,711.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 15,126.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 364,712.1 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 47,124.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **364,712.1** мянган төгрөг буюу 87.0 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ийн зардал 36,590.6 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 10,002.5 мянган төгрөгөөр, аудит баталгаажуулалтын зардал 486.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгал халдваргүйжүүлэлт 91.0 мянган төгрөг, сумын ЭМТ-аас тусгаарлалтын гал тогоонд ажилласан ажилчдын илүү цагийн хөлс 1,407.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь *“Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.”* гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь *“цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%”* гэж заасан боловч цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгосон байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “*Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэгт 419,119.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 364,712.1 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 13.0 хувиар хэмнэж Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 132.0 мянган төгрөгийн акт, 532.1 мянган төгрөгийн албан шаардлага, 2,500.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 35,130.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 21,836.8 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 1,450.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 акт тогтоож, 11,843.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд санхүүгийн тайланд 10,918.4 мянган төгрөгийн хөрөнгийн орлогыг дутуу тусгасан, дахин үнэлгээний нэмэгдэл дансыг 10,918.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байсныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Сумын Засаг даргын 2021 оны А/01, А/17, А/21 дугаар захирамжаар багш ажилтнуудын илүү цагийн хөлсийг тушаалд заасан цагаас илүү тооцон 744.1 мянган төгрөгийн цалин олгосон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Сахилгын шийтгэл ногдуулсан жижүүр Б.Болдод сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад 706.6 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 131.4-д “*Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно*”, Засгийн газрын 2017 оны 346 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгох журам”-ын хавсралт 2.1-д “*Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыгбайгууллагын орчин, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш албан хаагчдад олгоно*” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байгаа албан хаагчид олгосон улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 11,873.2 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

1.2 Бараа материалын данстай холбоотой

1.2.1 Хүнсний материалын худалдан авалтыг 20 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн дээр түүвэрлэж үзэхэд гэрээнд санал болгосон үнийн дүнгээс 8-10 хувиар нэмэгдүүлэн худалдан авалт хийсэн боловч гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-д “Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлсний үнэнд захиалагч дараах тохиолдолд тохируулга хийхээр гэрээнд тусгаж болно”, 40.4.1-д “хоёр жилээс дээш хугацаанд хэрэгжих гэрээний явцад хэрэглээний үнийн индекс өөрчлөгдсөн, 40.4.2-д “суурь үнэ огцом өөрчлөгдсөн”, 41.1.2-д “энэ хуулийн 40.4-д зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэхийг өөрчлөхийг хориглоно” гэж заасны дагуу бараа бүтээгдэхүүний суурь үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| Д/Д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|-------------------------------------|----------------------|----------|-----------|----------|---------------|---------|-----------------|-----|---------|----------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэг | 6 | 35,130.7 | 2 | 21,836.8 | 2 | 1,450.7 | | | 2 | 11,843.2 |

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.